



**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

**“Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага,  
дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 14.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

- 1.”Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн  
198 дугаар тогтоолын хавсралт

## ДААТГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ДАГАЖ МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Даатгалын тухай хуулийн 20.1-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын компани (цаашид “даатгагч” гэх)-ийн даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлттэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгагчийн эрх бүхий албан тушаалтан нь Хорооны 2010 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-г заасан шаардлагыг хангасан байна.

### Хоёр. Нэр томьёо

2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “даатгалын гэрээ байгуулах эрхтэй этгээд” гэж даатгалын компанийн орон тооны ажилтан, даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгчийг ойлгоно.

2.1.2. “даатгалын гэрээ эзэмшигч” /policyholder/ гэж даатгагчтай байгуулах даатгалын гэрээнд гарын үсэг зурсан этгээдийг ойлгоно.

2.1.3. “бенефишер” гэдгийг ашиг сонирхол бүхий этгээд гэж ойлгоно.

~~2.1.4. “хүртээмжтэй даатгал” гэж иргэн бүрийг хамруулах зорилго бүхий, даатгалын гэрээний үг хэллэг нөхцөл нь энгийн ойлгомжтой, даатгалын хураамжийн хэмжээ болон нөхөн төлбөрийн хасалт бага байх сайн дурын даатгалын бүтээгдэхүүнийг ойлгоно~~ /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/ – Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

### Гурав. Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага

3.1. Даатгагч нь даатгалын үйл ажиллагаандаа дараах шаардлагыг байнга хангаж ажиллана:

3.1.1. Даатгалын тухай хууль холбогдох бусад хууль тогтоомж болон даатгалын багц дүрмийг дагаж мөрдөх;

3.1.2. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байртай байх;

3.1.3. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах техник тоног төхөөрөмж, даатгал, санхүү, бүртгэлийн программ хангамжтай байх;

3.1.4. Компанийн бүтэц дотор даатгалын тохиолдлыг газар дээр нь шалгаж баталгаажуулах, даатгуулагчийн нөхөн төлбөр, өргөдөл, гомдлыг барагдуулдаг, эрх ашгийг нь хамгаалдаг нэгжтэй байх;

3.1.5. Даатгагч нь компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа болон давхар даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын нэгж, эсхүл албан тушаалтантай байх. Дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаанд мөрдөх журмыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан байх;

3.1.6. Компаниас гарсан шийдвэр болон компанийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх дотоод журам, заавар, эрх зүйн баримт бичгийг архивлан хадгалах;

3.1.7. Даатгагч нь өөрийн хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл болон түүнд орсон өөрчлөлтийн талаар хувийн хэрэг /хавтаст материал/ үүсгэн хадгалах;

3.1.8. Даатгагч нь хаяг, холбоо барих утас, даатгалын бүтээгдэхүүний дэлгэрэнгүй танилцуулгыг мэдээлсэн өөрийн цахим хуудастай байх;

~~3.1.9. Даатгуулагчтай байгуулах даатгалын гэрээний загварыг зах зээл дээр борлуулахаас өмнө Хорооны Даатгалын газарт ирүүлж, хянуулсан байх; /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

~~3.1.10. Хорооны Даатгалын газарт ирүүлж хянуулсан даатгалын гэрээний загварт өөрчлөлт орсон тухай бүр шинэчлөгдсөн даатгалын гэрээний загварыг Хорооны Даатгалын газарт ирүүлж байх; /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

3.1.11. Даатгагчаас зах зээл дээр борлуулах гэж буй бүтээгдэхүүн нь Хорооны 2012 оны 356 дугаар батлагдсан “Сайн дурын даатгалын хэлбэр”-т заасан бүтээгдэхүүний алинд нь хамаарах талаар хянуулсан байх; /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.1.12. Даатгагчийн эрх бүхий албан тушаалтан /Үүнд: Компанийн тухай хуулийн 84.1-т заасан дараах этгээд хамаарна: Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга/ нь шинээр томилогдох болон өөрчлөгдөх тухай бүр Хорооноос зөвшөөрөл авч байх; /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.1.13. Даатгагч холбогдох хууль, журамд заасан баримтыг үндэслэн нөхөн төлбөр өгч байх;

3.1.14. Даатгагч холбогдох хууль тогтоомжид нийцсэн улирал тутмын санхүүгийн тайлан болон жилийн эцсийн санхүүгийн тайланг Даатгалын тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж байх;

3.1.15. Даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг Даатгалын тухай хуулийн 29.5-т заасан хугацаанд нийтэд хэвлэлээр мэдээлж байх;

3.1.16. Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгээ Даатгалын тухай хуулийн 29.7-д заасны дагуу хадгалдаг байх;

3.1.17. Даатгагч нь Даатгалын тухай хуулийн 33.1, мөн хуулийн 33.5 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангаа баталгаажуулах зорилгоор томилсон аудитортой байх бөгөөд даатгагч аудиторыг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэж байх;

3.1.18. Хорооны 2007 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-д заасан шаардлагыг хангасан актуарчтай байх;

3.1.19. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүнтэй адил эрх бүхий этгээдийн баталсан давхар даатгалын жилийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацааны дотор Хороонд ирүүлж байх;

3.1.20. Даатгагч давхар даатгалын нарийвчилсан тайланг гаргаж, холбогдох журамд заасан хугацааны дотор Хороонд ирүүлж байх;

3.1.21. Төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхгүй байх.

3.1.22. Даатгагч нь өөрийн дансны санхүүгийн гүйлгээг хянуулдаг байхаар Хорооны тухайн даатгалын компанийг хариуцсан улсын байцаагчид нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэл олгох, эсхүл сар бүр Хорооны сэдэвчилсэн шалгалтаар дансны гүйлгээг шалгуулдаг байх шаардлагыг хангасан байх.

3.1.23. Даатгалын компани нь нэг буюу түүнээс дээш тооны хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байх/*Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 133 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.1.24. Тус журмын 3.1.23-г заасан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна. /*Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 133 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.1.25. Даатгалын компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллавал зохино.” /*Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 133 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.1.26. Даатгагч нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, хувьцаат компани, гадаадын хөрөнгө оруулалттай компанитай гэрээ байгуулсных нь төлөө даатгалын төлөөлөгчид олгосон төлбөр, хөлс, даатгуулагч, даатгалын гэрээний талаарх мэдээллийг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу улирал бүр гарган Хороонд хүргүүлж, дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор өөрийн цахим хуудсанд олон нийтэд ил тод зарлан мэдээлэх /*Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 277 дугаар тогтоолоор нэмсэн/*

~~3.2. Даатгагч даатгалын бүтээгдэхүүнийг зах зээл дээр бөрлуулахаас өмнө дараах баримт бичгийг бүрдүүлж, Хороонд бүртгүүлнэ: /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор~~

~~нэмсэн~~/-Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

~~3.2.1. Энэхүү журмын 1 дүгээр хавералтын дагуу гаргасан даатгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэх хүсэлт; /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн~~/-Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

~~3.2.2. Иргэний хуулийн 431.4 дэх хэсэгт заасан нөхцөлийг тусгасан даатгалын бүтээгдэхүүний гэрээний загвар; /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн~~/-Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

~~3.2.3. Даатгалын бүтээгдэхүүний баталгааны загвар; /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн~~/-Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

~~3.2.4. Даатгалын бүтээгдэхүүний танилцуулга болон даатгалын хураамжийн тооцоолол, танилцуулга /даатгалын хураамжийн тооцооллыг зээлийн гэрээний хугацааны туршид хураамжийг нэг удаа эсхүл сар улирал, хагас жилээр төлөгдөхөөр тооцсон байх, барьцаа хөрөнгийн хувьд байгалийн эрэдэл, галын эрэдэл гэх мэт эрэдэлүүдийг нарийн тооцсон байх, амь насны даатгалын хувьд нас баралтын хүснэгт, хүүгийн хүчин зүйлийн тооцооллыг тусад нь хавсаргана~~/-Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/-Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.3. Орон сууцны урт хугацааны зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэхэд Хороо дараах шаардлагыг тавина: /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/

3.3.1. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагч “Орон сууцны зээлийн барьцаа хөрөнгийн даатгалын гэрээ”-г борлуулахад, Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагч “Орон сууцны зээлдэгчийн амь насны даатгалын гэрээ”-г борлуулахад энэ нэр томъёоноос өөрөөр нэрлэхийг хориглох бөгөөд эдгээр бүтээгдэхүүнийг багцалж борлуулах нөхцөлд “Орон сууцны зээлийн даатгалын гэрээ” гэж томъёолох; /-Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/

3.3.2. Даатгагч орон сууцны урт хугацааны зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг даатгахдаа Монголбанкнаас баталсан ипотек (моргэйж)-ийн зээлийн холбогдох журамд заасан зээл авах шаардлагыг хангаагүй зээл хүсэгчийг даатгахгүй байх; /-Энэ заалтыг

*Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.3.3. Зээлдэгчийн амь насны даатгалын гэрээний хугацаа нь зээлийн гэрээний хугацаанаас багагүй байх; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.3.4. Зээлдэгчийн амь насны даатгалын хувьд даатгагч урт хугацааны нөөц байгуулах; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.3.5. Даатгагч нь банкны орон сууцны зээлийн нөхцөл, шаардлагад өөрчлөлт орсон эсэхийг судалсан байх; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/*

3.3.6. Орон сууцны урт хугацааны зээл (моргэйж, ипотек)-ийн хөрөнгийн даатгалын бүтээгдэхүүнийг борлуулахдаа эрсдэлийг тараах зорилгоор нэг байршилд буй хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь тухайн даатгагчийн нөөцийн сангийн хөрөнгөөс давсан тохиолдолд нэг даатгагч дангаараа даатгахыг хориглоно; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/*

~~3.4. Хурдан морины уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэхэд Хороо дараах шаардлагыг тавина: */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/*~~ *Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

~~3.4.1. Даатгалын эрсдэлд үндэсний баяр наадам болон бүх түвшний хурдан морины уралдаан, түүний бэлтгэл, сунгааны үед үүсч болзошгүй бүхий л гэнэтийн осол, гэмтэл болон даатгалын гэрээний хугацаанд бий болж болзошгүй бусад ахуйн гэмтэл, ослыг тусгах. */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/*~~ *Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

~~3.5. Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэхэд Хороо дараах шаардлагыг тавина: */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/*~~ *Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

~~3.5.1. Даатгалын хураамж болон эрсдэлийн хэмжээ нь бага, дунд орлоготой иргэдэд зориулагдсан байх; */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/*~~ *Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

3.5.2. ~~Даатгалын гэрээнд тусгасан нөхөн төлбөрийн хасалтын тоо 5 аас ихгүй байх; /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27 ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/~~ Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.5.3. ~~Даатгалын гэрээ нь хоёрдмол утга санаагүй, бусдад шууд ойлгохоор үг, хэллэгтэй байх; /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27 ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/~~ Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.5.4. ~~Даатгалын нөхөн төлбөрийг 10 хоногт олгодог байх; /даатгалын зуучлагч болон хуулийн этгээд даатгалын төлөөлөгчөөр дамжуулан даатгалын нөхөн төлбөрийг олгох боломжтой/~~ Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27 ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/ Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.6. Энэ журмын 3.5 дахь хэсэгт заасан хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг Хороо бүртгэхдээ код огох бөгөөд уг код нь “ХД” үегийн ард дугаар, оныг илэрхийлсэн цифрийг тусгана. /Тухайлбал: ХД00012014 гэснийг 2014 оны 1 дугаартай хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн гэж ойлгох /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27 ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.7. Тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэхэд Хороо дараах шаардлагыг тавина: /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27 ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.7.1. Тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүний гэрээнд тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоонд өрөөгүй тээврийн хэрэгсэлд нөхөн төлбөр олгохгүй байх болон богино холболтын улмаас галд шатах мөн замын хөдөлгөөний дүрэм зорчсон, техникийн шаардлага хангаагүй зэрэг ерөнхий заалтын тусган даатгуулагчид нөхөн төлбөр олгохоос татгалзах заалтыг даатгалын гэрээнд тусгахыг хориглоно. /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27 ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/ Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

3.8. Даатгагч Хороонд бүртгүүлсэн даатгалын гэрээний загвараас өөр нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах, мөн даатгагчийн төлөөлөн удирдах зөвлөлөөс бусад эрх бүхий албан тушаалтан нь өөр даатгагчийн эрх бүхий албан тушаалтнаар ажиллахыг хориглоно. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/

~~3.9. Хороо даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэх эсэхийг ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэх бөгөөд бүртгэхээ татгалзсан тохиолдолд энэ талаар даатгагчид албан бичгээр хариу өгнө. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27 ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн// Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

~~3.10. Хорооны Даатгалын газар даатгалын бүтээгдэхүүний бүртгэлийг файлаар бүртгэх бөгөөд бүртгэлд орсон өөрчлөлтийг ажлын 2 өдрийн дотор хийнэ.”/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар сарын 27 ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн// Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

### **Дөрөв. Даатгагчийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд тавигдах шаардлага**

4.1. Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгал болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.10-т заасны дагуу зөвшөөрөл авсан даатгалын компанийн салбар нь тус журмын 3.7-3.8<sup>1</sup>,3.8<sup>3</sup> –т заасан шаардлагыг хангаж ажиллахаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байвал зохино:

4.1.1. Улаанбаатар хот дахь салбарын захирал таван зуун мянган төгрөг хүртэл, хөдөө орон нутаг дахь салбарын захирал гурван зуун мянган төгрөг хүртэл дүнтэй нөхөн төлбөрийг бие даан шуурхай шийдвэрлэдэг байх;

4.1.2. Арилжааны банкны салбарт өөрийн данстай байх;

4.1.3. Даатгалын компанийн салбар нь жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд шуурхай албатай байх ба 24 цагаар дуудлага хүлээн авах суурин утастай, даатгалын тохиолдол болоход хохирлын хэмжээг газар дээр нь очиж тогтоох зориулалтын автомашинтай, даатгалын талаарх мэдээлэл оруулж хадгалах, шаардлагатай мэдээг мэдээллийн санд өгч нэгтгүүлэх интернэтэд холбогдсон программ хангамжтай байх;

4.1.4. Салбарын даатгалын үйл ажиллагаа явуулах газрын хаяг өөрчлөгдсөн тохиолдолд даатгагч ажлын 5 хоногийн дотор Хороонд бичгээр мэдэгдэж байх;

4.1.5. Салбарын сүүлийн 2 жилийн даатгалын анхан шатны баримт, нөхөн төлбөр олгосон баримт болон салбарын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг архивлан хадгалж байх;

4.1.6. Салбар нь Хорооны 2009 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ын 30, 31 дүгээр хавсралтын дагуу гаргасан тайлан мэдээг улирал бүр Санхүүгийн зохицуулах хорооны аймаг, нийслэл, дүүрэг дэх орон нутгийн төлөөлөгчид хүргүүлж байх;

4.2. Даатгалын төлөөлөгчийн газар нь Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгал болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.29–т заасан шаардлагыг үйл ажиллагаандаа хангаж ажиллана.



## **Тав. Даатгалын гэрээ байгуулах болон даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаанд тавигдах шаардлага**

5.1. Даатгалын гэрээ байгуулахад дараах шаардлага тавигдана:

5.1.1 Даатгуулагчтай байгуулж байгаа даатгалын гэрээ нь монгол хэл дээр үйлдэгдсэн, утга санаа, үг хэллэг нь ойлгомжтой, төөрөгдүүлсэн болон хоёрдмол санаа агуулаагүй байх;

5.1.2. Даатгалын гэрээ дуусгавар болох хугацаанаас өмнө даатгалын гэрээ цуцлагдсан тохиолдолд даатгалын хураамжийн буцаалтыг даатгуулагч бичгээр хүсэлт гаргаснаас хойш 7 хоногийн дотордаатгуулагчид олгох;

5.1.3. Бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулах / даатгалын гэрээнд ажилтнуудыг ажил олгогчтөлөөлж, оршин суугчдыг сууц өмчлөгчдийн холбоо төлөөлж гэх мэт/ тохиолдолд тухайн бүлэгт хамаарах даатгуулагч бүрд Иргэний тухай хуулийн 433.1-т заасны дагуу даатгагчаас гарын үсэг зурсан даатгалын баталгааг гардуулах үүрэгтэй.

5.1.4. Энэ журмын 5.1.3-т заасан даатгалын баталгаанд даатгуулагчийн овог, нэр, нас, хүйс, даатгалын эрсдэл, нөхцөл, хасалт, даатгалын хураамж, үнэлгээ, даатгагчийн хаяг, холбоо барих утсыг заавал тусгасан байна.

5.1.5. Даатгагч эсхүл түүний төлөөлөгч нь бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулахаас өмнө даатгуулагч нэг бүрт тухайн даатгалын бүтээгдэхүүний талаар танилцуулж, зөвшөөрлийгбичгээр авсан байна.

5.1.6. Даатгуулагч нь даатгалын гэрээ байгуулахын тулд бүлэг байгуулахыг хориглоно.

5.1.7.Хорооны 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-ын 5.1.3-д заасан шаардлагыг биелүүлээгүй даатгалын төлөөлөгчид аливаа төлбөр, хөлс төлөх, өөрийн нэрийн өмнөөс даатгалын гэрээг байгуулах эрх олгохыг хориглоно/*Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 277 дугаар тогтоолоор нэмсэн/*

5.2. Даатгалын нөхөн төлбөр олгоход дараах шаардлага тавигдана:

5.2.1. Даатгагч даатгалын нөхөн төлбөр олгохдоо даатгуулагчийг чирэгдүүлэхгүй байх;

5.2.2. Даатгагч даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах, хасалт хийх нөхцөл бүхий заалтыг даатгалын гэрээнд тусгасан тохиолдолд татгалзах үндэслэл, хасалт хийх нөхцөл нь Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн аль зүйл, заалтад хамааралтай болох тухай тайлбарыг Хороонд ирүүлж, хянуулах;

5.2.3. Даатгагч хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг даатгуулагчаас шаардах тохиолдолд уг дүгнэлт гараагүй байхад даатгалын гэрээнд заасан хугацаа өнгөрсөн шалтгаанаар даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзахыг хориглох;

5.2.4. Даатгалын гэрээгээр тохиролцсоны дагуу даатгалын хураамжийг хэсэгчлэн, үе шаттай төлөхөөр тохиролцсон үед даатгалын тохиолдол учирвал даатгагч даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчийн төлсөн хураамжтай хувь тэнцүүлэн бууруулахыг хориглоно;

5.2.5. Урт хугацааны даатгалын гэрээ эзэмших эрх бүхий этгээд тухайн гэрээнд заагдсан даатгалын бенефишерт гэрээний эрхийн талаар бичгээр мэдэгдэх бөгөөд

бенефишер байхгүй, эсхүл энэ эрхээс татгалзсан, эсхүл нас барсан тохиолдолд даатгалын гэрээ эзэмшигчийн хууль ёсны өв залгамжлагчид даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

5.3. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагч даатгалын нөхөн төлбөр олгохдоо дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.3.1. Даатгагч даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг авсан даруйдаа даатгуулагчид хариу өгч, даатгуулагчаас авах арга хэмжээний талаар тодорхой мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд даатгагч 72 цагийн дотор даатгалын тохиолдлыг шалгаж баримтжуулах өөрийн ажилтанг эсхүл даатгалын хохирол үнэлэгчийг томилно.

5.3.2. Даатгалын хохирлын үнэлгээний тайланг баталгаажуулж ирүүлснээс хойш даатгагч 14 хоногийн дотор багтаан даатгалын нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг шийдвэрлэж даатгуулагчид бичгээр мэдэгдэх бөгөөд даатгалын нөхөн төлбөрийг олгосон байна.

5.4. Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагч нөхөн төлбөр олгохдоо дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.4.1. Урт хугацааны даатгалын компани даатгалын тохиолдлын нэхэмжлэл авсан даруйдаа бүртгэж, 7 хоногийн дотор даатгуулагчаас нэмэлт материалыг багцаар нь шаардаж болно.

5.4.2. Шаардагдах бүх материалыг авсанаас хойш 30 хоногт багтаан нэхэмжлэлийг барагдуулах эсхүл олгохгүй байх нөхцөл шалтгааныг дурдаж даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ.

5.5. Даатгагч даатгалын гэрээ болон холбогдох журамд заасан хугацаанд даатгалын нөхөн төлбөр олгоогүй бол Иргэний хуулийн 232.6 дахь хэсэгт заасны дагуу хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги тооцох заалтыг даатгалын гэрээнд тусгасан байна.

5.6. Аливаа этгээдээс даатгалын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн гомдол, гарсан маргааныг шийдвэрлэсэн Хорооны шийдвэрийг эс зөвшөөрч, Даатгалын тухай хуулийн 82.1-д заасны дагуу гомдол гаргаагүй тохиолдолд даатгагч Хорооны шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

5.7. Даатгагч энэ журмын 5.6 дахь заалтыг биелүүлээгүй нь Даатгалын тухай хуулийн 67.1.1, 68 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээ авах үндэслэл болно.

5.8. Энэ журмын 5.1-5.7 дахь заалт нь Жолоочийн албан журмын даатгалд хамаарахгүй */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 133 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан /*

5.9. Даатгагч даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулахдаа даатгалын гэрээ байгуулах эрхтэй этгээдээр дамжуулж гэрээ байгуулна.

5.10. Даатгалын гэрээ байгуулах эрхтэй этгээд нь 2 жил тутамд зохион байгуулсан даатгалын сургалтад хамрагдсан байна.

5.11. Хорооны 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-ын 2.1.3-т заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлээгүй даатгалын төлөөлөгчид аливаа хөлс, төлбөр төлөхийг хориглоно */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 277 дугаар тогтоолоор нэмсэн/*

5.12. Даатгагч нь даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхэлсэн хөлс, төлбөрийг арилжааны банк дахь даатгалын төлөөлөгчийн дансанд бэлэн бусаар шилжүүлэн олгоно.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 372 дугаар тогтоолоор нэмсэн/*

### **Зургаа. Хяналт, хариуцлага**

6.1. Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтэд Хорооны Даатгалын газраас байнгын хяналт тавьж ажиллана.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---

*“Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 1 дүгээр хавсралт  
/Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тогтоолоор нэмсэн/  
/Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 407 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

**ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БҮРТГҮҮЛЭХ  
ХҮСЭЛТ**

Огноо:.....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо

Засгийн газрын 4-р байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46, Монгол Улс

Даатгагч ..... ХХК нь Даатгалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн даатгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэх хүсэлтэй тул дараах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж хүргүүлсэн болно:

1. даатгалын бүтээгдэхүүнийг гэрээний загвар;
2. даатгалын бүтээгдэхүүний баталгааны загвар;
3. даатгалын хураамжийн тооцоолол, танилцуулга;

Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон бол хариуцлагыг манай компани хүлээх болно.

Тус компанийн хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, ..... даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэж өгнө үү.

Хүсэлт гаргагчийг төлөөлж:

..... ХХК-ийн гүйцэтгэх захирал:

.....  
.....

(гарын үсэг) (овог, нэр)

.....  
(тамга тэмдэг)

*“Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ын 2 дугаар хавсралт  
/Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 277 дугаар тогтоолоор нэмсэн/*

**ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ОЛГОСОН ШИМТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

20.... оны ..... улирал

д/д	Даатгалын төлөөлөгчийн нэр	Даатгуулагчийн нэр <sup>1</sup>	Байгууллагын төрөл <sup>2</sup>	Даатгалын төлөөлөгчийн шимтгэлийн дүн <sup>3</sup>
1				
2				
3				

<sup>1</sup> Даатгуулагчийн нэрийг товчлолгүйгээр бүрэн бичнэ.

<sup>2</sup> Байгууллагын төрлөөр дараах дугаарыг бичнэ: Төрийн байгууллага -1, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж -2, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж -3, Хувьцаат компани – 4, Гадаадын хөрөнгө оруулалттай компани – 5. Хэрвээ байгууллагын төрөл давхцсан тохиолдолд дугааруудыг хамтад нь бичнэ.

<sup>3</sup> Тухайн улиралд даатгуулагчтай байгуулсан нийт гэрээний орлогоос олсон шимтгэлийн дүнг бичнэ.